

Хорин долдугаар зүйл

Сураггүй болсныг хүлээн зөвшөөрөх, нас барсныг мэдэгдэх, нас барсан тухай тогтоох

1. Сураггүй алга болсныг хүлээн зөвшөөрөх, нас барсныг мэдэгдэх, - нас барсан цаг уеийг / нас барсан гэж / тогтоох яздлыг уг иргэнийг сураггүй алга болох буюу нас барахын өмнө харьяалж байсан Хэлэлцэн Тохирогч Этгээдийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр гүйцэтгэнэ.

2. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн байгууллага хэрэв эрэлт хусэлтээ гаргаж байгаа иргэний эрх, ашиг сонирхол нь оршин суугаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хууль тогтоомжинд үндэслэгдсэн бол тууний эрэлт хусэлтээр Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн иргэний сураггүй алга болсныг хүлээн зөвшөөрөх буюу нас барсныг мэдэгдэх, эсхүл нас барсан цаг уеийг / нас барсан гэж / тогтооно.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь ангид дурдсан тохиолдолд Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн байгууллага өөрийн улсын хууль тогтоошгийг баримтлана.

2. Гэр бүлийн хэрэг

Хорин наймдугаар зүйл

Гэрлэх

1. Гэрлэх нөхцлийг гэрлэхийг хусэгчдийн харьяалагдах Хэлэлцэн Тохирогч Этгээдийн тус тусын хуулиар тогтооно.

2. Гэрлэх хэлбэрийг нутаг дэвсгэрт нь гэрлэж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хууль тогтоомжоор зохицуулна.

3. Дипломат төлөөлөгчийн буюу консулын газрын хэрэглэх эрх бүхий гэрлэх хэлбэр нь тэрхуу дипломат төлөөлөгчийн буюу